



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

1005 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын
данс бүртгэлээс барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/81 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/895 дугаар захирамжийн тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын баланст бүртгэлтэй нийт 7,331,808.96 (долоон сая гурван зуун гучин нэгэн мянга найман зуун найман төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан эд хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар (Г.Давааням)-т зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй барилга байгууламжийг буулгах, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж, нийт 2,525,451.00 (хоёр сая таван зуун хорин таван мянга дөрвөн зуун тавин нэг) төгрөгөөр худалдан борлуулж, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул), өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийхийг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар (Г.Давааням)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/158 дугаар тушаалын хавсралт

ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Акталж данснаас хасах үндэслэл	Хоёрдогч түүхий эдийн үнэлгээ
1	Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны Бэлхийн Цагдаагийн постын барилга	2002	м2	48	7,331,808.96	4,582,380.67	2,749,428.29	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Цагдаагийн 2 дугаар хэлтсийн постын барилга барьсан	2,525,451.00
Нийт дүн					7,331,808.96	4,582,380.67	2,749,428.29		2,525,451.00